

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН**ЦӨСНИЙ ШАРЫН БЭТЭГ БУЮУ ЦӨСНИЙ ЧУЛУУ ӨВЧНИЙ ХУВИРАХ ЁС,
ЗАРИМ ЭМИЙН ҮЙЛДЛИЙН МЕХАНИЗМЫГ ШИНЖЛЭХ НЬ**

Тэмцэлт Ү.¹, Улаан-Од Х.¹, Наранзаяа Л.¹, Анхцацрал Л.¹, Болд Ш.²

¹“Ач” Анагаах ухааны их сургууль,

²Монголын анагаах ухааны академи

Email: ulaanod@ach.edu.mn

Abstract**ANALYSIS OF PATHOGENESIS OF BILE'S TRI-PA TUMOR OR GALLSTONES
AND THE MECHANISM OF SOME TRADITIONAL DRUG ACTION**

Temtselm U.1, Ulaan-Od Kh.1, Naranzaya L.1, Ankhtsatsral L.1, Bold Sh.2

1“Ach” Medical University

2Mongolian Academy of Medical Sciences

Email: ulaanod@ach.edu.mn

Background

Some scholars believe that the study ancient medical works to gain insight into their scientific concepts and correctly understand the profound techniques of doctors are very important to development of traditional medicine in the 21st century. In “The WHO Traditional Medicine Strategy 2014-2023”, strengthen the study of traditional medical books is mentioned. According to epidemiological surveys, gallstones are a common disease worldwide. In the “Oral Instruction Tantra”, pathogenesis and treatment of gallstones mentioned and further refined in the Interpretation books. Although in modern times, doctors have published many papers and books on traditional medical treatment of gallstones and their pathogenesis based on the contents of ancient books and their own clinical experience, but in-depth analysis of the literature information and explanations have not been mentioned in detail.

Goal

According to the traditional medical theory to analyze the pathogenesis of bile's Tri-pa tumor or gallstones and the mechanism of some drug action.

Materials and methods

In our study, we used the book named “Oral Instruction Tantra” as main reference material and for research methods, we used the checklist method to list relevant information about the pathogenesis of gallstones and Nemert Yvuunii Uns-10 traditional drug from the literature, so as to provide preconditions for further analysis. The pathogenesis of gallstones and the action mechanism of Nemert Yvuunii Uns-10 were analyzed by theoretical analysis methods and the analysis-synthesis method was used to summarize the analysis results.

The study was carried out in accordance with “Academic Staff Code of Ethics” in the appendix of Ministerial Decree No. 454 in 2007.12.03 by Ministry of Education, Culture and Science, Mongolia.

Results

Affected by constitution, unaccustomed diet, inharmonious diet and naturally difficult to digest food, stomach fire reduced leads to food can not be corroded by decomposing phlegm, can not be melting by digestive bile and can not be separated by fire-accompanying wind. This causes food waste enter the nutritional essence which is transported to the liver. The pathological blood is produced when color-producing bile in the liver processes nutritional essence and eventually, bile's Tri-pa tumor or gallstones are caused by the accumulation of bile deposits from the pathological blood under the influence of wind.

We using Mongolian medicine theory to analyze the mechanism of action of Nemert Yvuunii Uns-10 in treating gallstones. In the prescription, Manufactured *Monetaria moneta* (Linnaeus), *Calcitum* and Boar dung are main ingredients, Have a crushing Tri-pa tumor or gallstones effect. The function of the *Aucklandia lappa* Decne supplement the efficacy of the main ingredients. *Trogopteroni Faeces*, *Lagotis Integrifolia* and *Carthamus tinctorius* L. treat pathologic blood in the liver. *Gentiana Barbata* and *Herpetospermum caudigerum* Wall have a reducing bile heat effect. *Punica granatum* L. has the effect of increasing stomach fire and promoting digestive function. *Terminalia chebula* Retz. homogenize the three humorus.

Conclusions

Reduced stomach fire leads to the production of pathological blood in the liver and eventually accumulation of deposits in bile is the cause of bile's Tri-pa tumor or gallstones. The mechanism of action of Nemert Yvuunii Uns-10 traditional drug for treat bile's Tri-pa tumor or gallstones is by breaking stones, treating pathological blood, reducing bile heat, increasing stomach fire to promote digestion and homogenizing the three elements.

Keywords: Gallstones, mechanism of action, pathogenesis, traditional medicine.

Pp. 20-27, Table 1, Pictures 2, References 21

Үндэслэл

XXI зууны УАУ-ны хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, эрдэмтэдийн бүтээн туурвисан анагаах ухааны ном, судрыг уншиж судлах, уг номонд байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамба нарын гарын авлага, увдисын гүн утгыг онож ойлгох нь чухал [1] хэмээн судлаачид үздэг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас гаргасан 2014-2023 онд “Уламжлалт анагаах ухаан (УАУ)-ыг хөгжүүлэх стратеги”-д УАУ-ы ном зохиолуудыг судлах ажлыг эрчимжүүлэх [2], мөн 2010 онд Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 386 тоот тушаалаар батлагдсан 2010-2015 онд “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр”-т УАУ-ы эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, Монголын УАУ-ы өв сан, ном судрыг судлах зэрэг зорилтууд багтжээ [3].

Цөсний чулуу (GSD) нь дэлхийд цөсний замын эмгэгүүдээс хамгийн түгээмэл тохиолддог өвчний нэг. Түүний тархалт барууны орнуудад 5.9-21.9%, Азид 3.1-10.7% хооронд хэлбэлздэг.

Ихэнх цөсний чулуу (75%) нь шинж тэмдэггүй байдаг ба шинж тэмдэг бүхий цөсний чулуу тээгчдийн бараг тал хувь нь жилийн дотор хоёр удаа өвдөлт мэдэрдэг. Эдгээр хүмүүст цочмог холецистит, цочмог холангит, цөснөөс үүдэлтэй нойр булчирхайн үрэвсэл үүсэх эрсдэл нэмэгддэг [4]. 2021 оны Монгол улсын хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээр хүн амын өвчлөлийн хоёрдугаар шалтгаан болсон хоол боловсруулах тогтолцооны өвчин нийт өвчлөлийн 16.0 хувийг эзэлж, цөсний хүүдий, цөсний зам ба нойр булчирхайн өвчин хоол боловсруулах тогтолцооны өвчнүүдийн 14.2 хувийг эзэлж байна [5].

УАУ-д цөсний чулуу өвчнийг цөсний шарын бэтэг өвчинтэй дүйцүүлэн авч үздэг [6]. “Увдисын үндэс”-т түүний хувирах ёс болон засах аргыг нарийн заасан [7] бөгөөд тайлбар сурвалж бичгүүдэд энэхүү эмчилгээний аргыг улам баяжуулж гүнзгийрүүлэн тэмдэглэжээ [8,9]. Орчин үед УАУ-ы эмч, эрдэмтэд цөсний чулуу өвчнийг эмчлэх талаар эмнэлзүйн практикт бага бус туршлага хуримтлуулж, нэлээдгүй эрдэм

шинжилгээний өгүүлэл, бүтээлүүд хэвлүүлжээ [10,11,12]. Эдгээр бүтээлүүдэд эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан, өөрийн практик туршлагаар баяжуулсан цөсний чулуу өвчнийг эмчлэх арга, эмчилгээний үр дүнг голлон бичсэн хэдий ч эх сурвалжийн мэдээллийн зарим гүнзгий утгыг задлан шинжилж тайлбар хийн тодруулах талаар хараахан тэмдэглээгүй байна.

Зорилго

Цөсний чулуу өвчний хувирах ёс буюу эмгэг жам, зарим эмийн үйлдлийн механизмыг УАУ-ы онолд тулгуурлан тайлбарлах.

Материал, арга зүй

Судалгааны гол материал

- བདུད་ཅི་སྒྲིང་པོ་ཡན་ལག་བརྒྱད་པ་གསང་བ་མན་དག་གི་རྒྱད་ལས་ ཏུ་བྱ་གསུམ་པ་མན་དག་གི་རྒྱད་ཅེས་བྱ་བ་བརྒྱགས་སོ།། Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндсээс гутгаар бүлэг увдисын үндэс хэмээх оршвой. Хэвлэлд бэлтгэсэн Ш.Болд, Б.Нямаа. Соёмбо принтинг. УБ, 2012

- Жигмэдданзанжамц. མཛོང་བ་དག་ལྟོད།། Үзэгсэдийн баясгалан. 086, АХХ, Бээжин, 2008

- Жамбалдорж. Монгол эмийг зөв таних толь. Төвөд хэлнээс Гэндэнжалцан орчуулсан. ӨМАХХ, Хөх хот, 1998

Судалгааны арга

- Магадлан жагсаах арга

Судалгааны хэрэглэгдхүүн материалаасаа цөсны чулуу өвчний хувирах ёс болон Нэмэрт явууны үнс-10 эмтэй холбоотой мэдээллүүдийг түүвэрлэн жагсааж, дараагийн тайлбар, тайлал хийх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү аргыг ашиглав.

- Онолын шинжилгээний арга

Бид судалгаандаа цөсны чулуу өвчний хувирах ёс болон нэмэрт явууны үнс-10 эмийн үйлдлийн механизмыг тайлбарлахад энэхүү аргыг хэрэглэв.

- Анализ-синтезийн арга

Энэхүү аргаар цөсны чулуу өвчний хувирах ёс болон нэмэрт явууны үнс-10 эмийн үйлдлийн механизмыг задлан шинжилж гарсан үр дүнг нэгтгэн дүгнэхэд ашиглав.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 454 дугаар тушаалын хавсралт “Эрдэм шинжилгээний ажилтны ёсзүйн дүрэм”-ийг баримтлан судалгааг хийж гүйцэтгэв.

Үр дүн

Өвчний хувирах ёсыг тодруулах

“Увдисын үндэс”-ийн бэтэг өвчнийг анагаах 7-р бүлэгт “Тунгалаг эс шингэж, элгэнд оршин цөсөнд унаад, цөсний шим тогтож хуйларваас цөсний шарын бэтэг болмуй” хэмээн цөсний шарын бэтэг буюу цөсний чулуу өвчин нь тунгалаг эс шингэснээс улбаалж цөсөнд унах, цөсний шим тогтох, хуйлрах, бэтэг буюу чулуу бий болох дараалаар үүсдэг болохыг заасан байдаг.

Тунгалаг эс шингэх эмгэг үйл явцыг тодруулбал:

УАУ-д эс шингэсэн өвчнийг мөн чанарын үүднээс цөв эс шингэх болон тунгалаг эс шингэх гэсэн 2 зүйлд ангилан авч үздэг ба тунгалаг эс шингэх нь хэрхэн үүсдэг талаар “Увдисын үндэс”-ийн эс шингэсэн өвчнийг анагаах 6-р бүлэгт “Гал тэгшитгэгч хий тунгалаг цөвийг эс ялгаж, цөв тунгалгийн судлын сүвээр орон өнгө урвуулагч шар тамирын цусыг боловсруулж үл чадсанаар элэгний оронд өнид оршин тунгалаг эс шингэсэн болмуй. Хуучирвал тунгалаг хуйлрах, цувирах, тархах, дүүрэх дөрөв болох ба хуйларснаас бэтэг өвчнүүд үүсмүй” хэмээн эс шингэсэн өвчнийг үүсгэх шүтээн, эс дадсан, үл зохирах, мөн чанар зэрэг 4 нөхцөлүүдийн улмаас ходоодны галын илч бууран идээ, ундааг ялзлагч бадган ялзалж үл чадах, шингээгч шар шингээн үл чадах, эцэст нь гал тэгшитгэгч хий тунгалаг цөвөө сайтар ялгаж үл чадсанаар цөв тунгалэгтайгаа холилдон элгэнд хүрэх бөгөөд элэгний оронд өнгө урвуулагч шар тамирын цусыг боловсруулах явцад муу цус үүсч эхлэх ба энэхүү үйл явц удаан хугацаанд үргэлжилбэл элгэнд муу цус дэлгэрч тунгалаг эс шингэх эмгэг өөрчлөлт бий болхыг үзүүлэв.

Цөсөнд унах нь: Элгэнд боловсорсон цусан тамир тунгалаг цөв ялгарч, тунгалаг нь махан тамирыг төлжүүлэх ба цөв нь савны цөс буюу цөсний шингэн болж ялгарна хэмээн УАУ-д үздэг. Энэ тухай “Хөх биндэрьяа”-д “Идээний тунгалаг элэгний оронд хүрч элгэнд орших бадган, шар, хий гурвын үйлдлээр цус болох ба цусны тунгалаг нь мах, цөв нь цөс болно” хэмээн заасан байдаг. Элгэнд тунгалаг эс шингэж үүссэн муу цус тунгалаг цөв ялгарахад түүний цөв болох цөсөнд халуун үүсэх бөгөөд цөвнүүд холилдоно.

Цөсний шим тогтох: “Алтан хадмал”-д “Идээ, ундааг шингээх илчийн суурь нь ходоодонд орших шингээгч шар, түүнийг илчийн суурь хэмээсний учир нь галын илч бүгдийн эрхэм

болхоор үл барам өвчний шалтгаан 3 гэм, тунгалаг таргүүтэн 7 тамир, баас тэргүүтэн 3 хир бүхэнд орших хуваарь нь цөм галын илч болно” хэмээсэн ба “Хөх биндэрьяа”-д “Ходоодонд бадган, шар хоёр идээг ялзалж боловсруулан, гал тэгшитгэгч хий тунгалаг цөвөө ялгаад 7 тамирт дараалан дамжихдаа өөр өөрийн галын илчээр боловсорно. Энд галын илч хэмээсэн нь шингээх хүчний дотроос голлох үйлдлийг үзүүлдгээр нь нэрлэсэн. Үнэндээ тамир тус бүрийн оронд бадган, шар, хий гурвын үйл болох ялзлах, боловсруулах, ялгах нь дараалан үйлдэгдэх юм” хэмээн заасан байдгаас үзэхэд цөсний тунгалаг, цөвийн ялгаралтын үйл ажиллагаа нь түүнд орших ходоодны галын илчээс эхтэй хуваарь илчийн үйлдлээр явагдна. Ходоодны гол галын илч буурсантай холбоотойгоор цөсөн дэх хуваарь илчийн хүч багасах бөгөөд үүний үр дүнд цөсний тунгалаг, цөвийн ялгаралт муутгах, ялангуяа тунгалаг эс шингэснээс улбаалж цөсөнд холилдсон цөвийг ялзлах, боловсруулах, ялгаж үл чадснаар цөсөнд шим тогтох буюу тунадас үүснэ.

Хуйлрах нь: Цөсөнд тогтсон шимийг хийгээр бөөгнөрүүлэн дахин дахин бүрхэж, нягтруулан

хатууруулахыг заана. “Увдисын үндэс”-ийн бэтэг өвчнийг анагаах 7-р бүлэгт “Тунгалаг эс шингэж, ходоодонд онь удсаныг бадган хүйтэн шалтгаан болж хийгээр бөөгнөрүүлэн дахин дахин бүрхэж хатууран боловсорвоос тунгалаг эс шингэсэн чулуун бэтэг болох” хэмээн хуйлрахын утгыг заасан байдаг (Зураг 1).

Өвчний мөн чанарыг тодруулах нь: “Увдисын үндэс”-ийн эс шингэсэн өвчнийг анагаах бүлэгт “Цөв эс шингэсэн шинэ цаг дор алхуулбаас тустай боловч хуучирч тунгалаг эс шингэсэн дор хор адил болмуй. Юун хэмээвээс тунгалаг элгэнд оршоод шар лугаа хавсарсан тул халуун, цөв ходоод олгойд бадган хий лугаа нийлснээр хүйтэн” хэмээн тунгалаг эс шингэсэн өвчний мөн чанар нь халуун болхыг тодорхойлсон байдаг тул элгэнд тунгалаг эс шингэснээс шалтгаалж үүсэх цөсний шарын бэтэг өвчний мөн чанар нь халуун болох боловч ходоодны галын илч буурсантай холбоотойгоор цөсөн дэх хуваарь илчээс шар хорогдож улмаар халуун, хурц бэлгэ чанаруудын хүч сулархад нөгөө талдаа бадган арвидан хүйтэн, мөхөө, наалдамхай бэлгэ чанарууд нэмэгднэ. Ингэснээр халуунд бадган хавсарч бадган халууны мөн чанартай болно.



Picture 1. Pathogenesis of bile's Tri-pa tumor

Нэмэрт явууны үнс-10 эмийн цөсний чулуу өвчний үеийн үйлдлийн механизмыг тодруулах нь:

“Үзэгсэдийн баясгалан”-д “Дэгд 1 цэн, алтан цэцэг 1 цэн, руда 2 цэн, барагшин 3 цэн, хонлэн

1 цэн, арүр 2 цэн, гүргэм 1 цэн, анар 1 цэн, догшин номхотгосон жонш 3 цэн, явууны үнс 3 цэнгээр найруулсан явууны үнс-10 нь халуун, хүйтэн бэтгийн зүйлийг дарах ба шарын бэтэгт гахайн баасны үнс 3 цэн нэммүй” [13] хэмээн

тэмдэглэжээ. Бид энэхүү нэмэрт явууны үнс-10 эмийн цөсний чулуу өвчний үеийн үйлдлийн механизмыг задлан шинжлэв.

Нэмэрт явууны үнс-10 эм нь чадлаар найруулсан найрлага. Түүний жор нь бэтгийг эвдэх чадалтай явууны үнс, догшин номхотгосон жонш, гарнаг буюу хүчин төгөлдөр түлсэн гахайн баас болон руда, элгэнд дэлгэрсэн муу цусыг анагаах чадалтай барагшин, хонлэн, гүргэм, шарыг

дарах чадалтай дэгд, алтан цэцэг, галын илчийг үүсгэн бадган хүйтнийг анагаах анар, махбодыг тэгшитгэх арүр зэрэг 5 бүлэг эмийн түүхий эдүүдээс бүрднэ. Жорын бүрэлдхүүнээс явууны үнс, гарнаг, руда зэрэг эмүүд нь бүлээн, анар нь халуун, барагшин, дэгд, алтан цэцэг, хонлэн, гүргэм зэрэг нь сэрүүн, жонш, арүр нь тэгш чанартай байх ба жорын бүлээн чанар өчүүхэн давамгайлна (Хүснэгт 1).

Table 1. Ingredients, dosage, efficacy and performance of Nemert Yvuunii Uns-10

№	Бүрэлдхүүн	Хэмжээ / цэн/	Чадал	Чанар	Чанарын хувь /%/
1.	Явууны үнс	3	Бэтгийг эвдэх	Бүлээн	38
2.	Гарнаг	3	Бэтгийг эвдэх	Бүлээн	
3.	Руда	2	Бэтгийг эвдэх	Бүлээн	
4.	Анар	1	Бадганыг анагаах	Халуун	5
5.	Жонш /ДН/	3	Бэтгийг эвдэх	Тэгш	24
6.	Арүр	2	Махбодыг тэгшитгэх	Тэгш	
7.	Барагшин	3	Муу цусыг анагаах	Сэрүүн	33
8.	Дэгд	1	Шарыг дарах	Сэрүүн	
9.	Алтан цэцэг	1	Шарыг дарах	Сэрүүн	
10.	Хонлэн	1	Муу цусыг анагаах	Сэрүүн	
11.	Гүргэм	1	Муу цусыг анагаах	Сэрүүн	

Нэмэрт явууны үнс-10 жорын бүрэлдхүүн эмүүдийг цөсний шарын бэтэг өвчний хувирах ёстой холбон шинжилбэл:

- Явууны үнс /Manufactured Moneta moneta (Linnaeus)/: “Цагаан болор толь”-д явууны үнсийг “Цус зогсоож, өгөр, усан хаван, шар усыг хатаах, хуйларсныг эвдэн нүдэнд туслах” чадалтай хэмээн заасан байдаг. Нэмэрт явууны үнс-10 эмд голлох эмээр орж, цөсөнд хуйларч үүссэн шарын бэтэг буюу чулууг эвдэх үйлдлийг үзүүлнэ.
- Догшин номхотгосон жонш /Calcitum/: Жоншын чадлыг “Номлолын үндэс”-т “Суулгахыг зогсоох, бадган халууныг анагаах”, “Эм заслын саран хаан”-д “Бэтэг ба хүйтэн өвчнийг арилгах”, “Малаяагийн бэрх үгийн тайлбар”-т “Архаг өвчний шалтгаан болох эс шингэсэн, бор бадган, шар, хор, хүйтний зүйл, бэтэг, хаван тэргүүтэн товчилбол дөрвөн аймаг их архагт тустай” хэмээн эх сурвалжуудад тэмдэглэсэн байдаг ба түүний догшин номхотголын чадлыг бэтгийг эвдэх нь илүү сайжирна хэмээн заасан байдаг. Нэмэрт явууны үнс-10 эмд голлох эмээр орсон нь цөсөнд хуйларч үүссэн шарын бэтэг буюу чулууг хайлуулах үйлдлийг үзүүлэх бөгөөд


тунгалаг эс шингэсэнээс үүссэн халуун цөсөн дэх хуваарь илч буурсантай холбоотойгоор арвидсан бадгантай нийлж үүссэн бадган халууныг дарах, мөн ходоодонд эс шингэсэн гэмийг арилгах үйлдлүүдийг үзүүлнэ.

- Гарнаг /Boar dung/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Гахайн баасыг зун навч, цэцэг дэлгэрэх цагт түүж, хүчин төгөлдөр түлсэн үнсийг гарнаг буюу хар гавар хэмээнэ. Эс шингэснийг шингээх, нян хижиг, шарын бэтгийг арилгана” хэмээн түүний чадлыг заасан байдаг. Явууны үнс-10 эмд голлох эмтэй ижил хэмжээгээр нэмэрлэсэн нь цөсөнд хуйларч үүссэн шарын бэтэг буюу чулууг задлах, өвчний үндсэн шалтгаан болсон эс шингэснийг шингээх нь тунгалаг, цөвийг сайтар ялгаж, элгэнд тамирын цус боловсрох үүдийг нээх үйлдлийг үзүүлнэ.
- Руда /Radix Aucklandiae./: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Руда хурц, бүлээн тул бэтэг хийгээд бадганыг эвдэнэ” хэмээв. Нэмэрт явууны үнс-10 эмийн голлох эмдүүдэд хавсарч цөсөнд хуйларч үүссэн шарын бэтэг буюу чулууг эвдэх, галын илч буурсны эрхээр цөсөнд арвидсан бадганыг дарах үйлдлийг үзүүлнэ.

- Барагшин /*Faeces Trogopteroi*/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Элэгний хуучирсан өвчнийг арилгана. Халуун өвчин бүхэнд тустай, ялангуяа ходоод, элэг, бөөрний халууныг анагаана” хэмээн барагшингийн чадлыг тэмдэглэсэн байдаг. Нэмэрт явууны үнс-10 эмд голлох эмтэй ижил хэмжээгээр орж, тэдгэрийн чадлыг дэмжихдээ шарын бэтгийн өвчин хувирах 2-р үе шат буюу элгэнд тунгалаг эс шингэж үүссэн муу цусан халууныг дарна.
- Хонлэн /*Lagotis Integrifolia*/: “Номлолын үндэс”-т “Муу цусыг хатаах, хямарсан халуун, цулын халууныг арилгана” хэмээн хонлэнгийн еспечадлыг заасан байдаг. Элгэнд тунгалаг эс шингэж үүссэн муу цусыг анагаан, цусан халууныг дарснаар тамирын цус сайтар боловсрон түүний цөв болох цөсний шингэн хэвийн ялгарч, муу цусны халуун болон цөвнүүд цөсөнд буух нь багасна.
- Гүргэм /*Carthamus tinctorius L.*/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Гүргэм нь элэгний өвчин бүхнийг арилган, судлын сүвийг бооно” хэмээсэн байдаг. Цөсний шарын бэтэг өвчний үед өвчин хувирах 2-р үе шат буюу элгэнд тунгалаг эс шингэж үүссэн муу цусан халууныг дарах үйлдлийг үзүүлснээр цөс хэвийн ялгарах нөхцөл бүрдэнэ.
- Дэгд /*Gentiana Barbata*/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Шарын халуунд сайшаав” хэмээн дэгдийн чадлыг заасан байдаг. Цөсний шарын бэтэг өвчний үед өвчин хувирах 2-р үе шат буюу элгэнд тунгалаг эс шингэж бий болсон муу цуснаас улбаатай үүсэх халуун болон муу цусан халуун цөсөнд унаж үүссэн цөсний шарын халууныг дарах үйлдлүүдийг үзүүлнэ.
- Алтан цэцэг /*Herpetospermum caudigerum Wall.*/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Шар саванд унасныг арилгана” хэмээн алтан цэцгийн чадлыг заасан байдаг. Түүний энэхүү чадал нь цөсний шарын бэтгийн өвчин хувирах 3-р үе шат буюу элгэнд тунгалаг эс шингэж бий болсон муу цусан халуун цөсөнд унаж үүссэн цөсний шарын халууныг дарах үйлдлийг үзүүлнэ.
- Анар /*Punica granatum L.*/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Анар ходоодны өвчнийг хоцролгүй арилгах бөгөөд илчийг үүсгэн бадган хүйтнийг дарна” хэмээн заасан байдаг. Цөсний шарын бэтэг өвчний үед ходоодны галын илчийг үүсгэн бадган хүйтнийг дарснаар тунгалаг цөв сайтар ялгарч, цөв тунгалгийн судлын

сүвээр орох нь багсан, элгэнд тамирын цус боловсрох үйл явц сайжирна.

- Арүр /*Terminalia chebula Retz.*/: “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Арүр нь биеийг төлжүүлэх бөгөөд илчийг үүсгэн идээг шингээж, хий, шар, бадганаас үүссэн өвчин бүхнийг анагаах үйлдэлтэй” хэмээсэн байдаг. Цөсний шарын бэтэг өвчний үед 3 гэрийн арвидсаныг дарж, хорогдсоныг арвидуулах, мөн илчийг үүсгэн идээг шингээж, тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулан, хийн хямралыг тэгшитгэнэ. (Зураг 2).



Picture 2. Mechanism of action of Nemert Yvuunii Uns-10

Хэлцэмж

Sun shi ming нарын судалгаагаар цусан дахь холестерин хэмжээ ихсэх үед элэгний эсийн плазмын мембранаар дамжин цөс рүү ялгарч, улмаар цөсөн дэх холестерин концентраци нэмэгдэн хэт ханаснаар цөсний хүүдийд талсжиж аажмаар цөсний чулуу үүснэ [14] гэж үзсэн үр дүнг УАУ-ы цөсний шарын бэтэг өвчний хувирах ёстой харицлалд: цусан дахь холестерин хэмжээ ихсэхийг “тунгалаг эс шингэж муу цус үүсэх”, элэгний эсийн плазмын мембранаар дамжин цөс рүү ялгарахыг “цөсөнд унах”, талсжихыг “цөсний шим тогтох”, цөсний чулуу үүсэхийг “хуйларч бэтэг болох” зэрэг эмгэг үйл явцуудтай дүйцүүлж болохоор байна.

Andrzej нарын судалгаагаар цөсний чулуу үүсэх гол механизмд цөсний холестерин хэт их шүүрэл, хэт ханасан ба талстжилт, салстын хэт шүүрэл, гель үүсэх, цөсний зогсонги байдал зэрэг орно. Цөсний хүүдийн гипомотик байдал нь хэт ханасан литоген цөсөөс үүссэн холестерин микро талстыг тунадасжуулна [15]. Салстын хэт шүүрэл, гель үүсэх, цөсний зогсонги байдал зэргийг цөсний шарын бэтэг өвчний хувирах ёсноос тунгалаг эс шингэж үүссэн муу цусны цөв цөсөнд буух, ходоодны галын илч буурсантай холбоотойгоор цөсөн дэх хуваарь илч багасч бадган арвидах буюу түүний хүнд, хүйтэн, тослог, наалдамхай, мохоо бэлгэ чанарууд давамгайлсантай холбон үзэж байна.

Цөсний хүүдийн холестерин болон пигмент чулуу нь удамшил, хүрээлэн буй орчин, хэсэг газрын болон системийн бодисын солилцооны эмгэгүүдийн нарийн төвөгтэй харилцан үйлчлэлийн үр дүнд үүснэ [16]. Таргалалт нь цөсний чулууг үүсгэх эрсдэлт хүчин зүйл [17]. Асуумж судалгаагаар биеийн хөдөлгөөн нь цөсний чулуу үүсэхээс сэргийлнэ. Цөсний чулуу үүсэх эрсдлийг ойролцоогоор 30% бууруулдаг [18]. Эдгээр судалгааны үр дүнгүүдийг УАУ дахь цөсний шарын бэтэг өвчнийг үүсгэж буй үндсэн шалтгаан болох галын илчтэй холбон шинжилхэд: УАУ-д удамшлын буюу биеийн төрөлх өвөрмөц чанартай холбогдуулан галын илчийг 4 ангилдаг. Хий болон бадган өвөрмөц чанартны ходоодны галын илч тэгшгүй, өчүүхэн байдгаас эс шингэсэн өвчинд өртөмтгэй болох бөгөөд улмаар тунгалаг эс шингэж цөсний шарын бэтэг үүсэх магадлал нь шар болон хавсарсан, хурсан өвөрмөц чанартнуудаас өндөр. “Увдисын үндэс”-т эс шингэсэн өвчний шүтээний нөхцөлийг “Хүйтэн хийн өвөрмөц чанартан” хэмээн заасан байдаг. Таргалалтыг УАУ-д тамир арвидах өвчний хүрээнд багтаан авч үздэг ба арвидах үйл явц нь ходоод болон тамирт орших галын илч буурснаас шалтгаална. Энэ тухай “Номлолын үндэс”-т “Өөрийн оронд орших галын илч болон тамир бүхэнд түгэх түүний хуваарь бадарч буурснаар тамир арвидах, хорогдох болно” хэмээн тэмдэглэсэн байдаг. Таргалалт буюу өөхөн тамир арвидах нь галын илч бууран тунгалаг эс шингэх эмгэг үйл явцаас үүсэх тул цөсний шарын бэтэг өвчний эрсдэлт хүчин зүйлд орно. Биеийн зохистой хөдөлгөөн нь шарыг үүсгэх явдал мөрийн нөхцөл болох учир шингээгч шар буюу галын илчийг үүсгэн улмаар тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулснаар цөсний шарын бэтэг өвчнөөс урьдчилан сэргийлж, түүний үүсэх эрсдэлийг бууруулна.

“Монгол анагаах ухааны эм найрлага судлал”-д явууны үнс-10 эмийн тайлбарыг “Тус найрлага нь чадлаар найруулсан сэрүүн чанартай найрлага. Бэтгийг эвдэх, өгөр, шар усыг хатаах явууны үнсээр гол болгож, архаг өвчнийг дарах, бэтгийг эвдэх догшин номхотгосон жоншоор дэдлүүлж, шарыг дархад алтанцэцэг, шарын бэтгийг эвдэхэд мөнгөн дэгдийг хавсруулсан тул шарын бэтгийг эвдэнэ. Муу цусыг хатаахад хонлэн, цусан халууныг арилгахад гүргэм, барагшинг хавсруулсан тул цусан бэтэгт тустай. Илчийг үүсгэхэд анар, бэтгийг эвдэхэд рудааг хавсруулсан нь идээний бэтэг, эс шингэсэн бэтэгт тустай. Махбодыг тэгшитгэх арүр орсон нь халуун, хүйтэн бэтэг бүхэнд тустай” [19] хэмээн явууны үнс-10 эмийн ерөнхий чадлыг түүний бүрэлдхүүнээр задалж тайлбарлажээ.

Явууны үнс-10 эм дэх цус шарын халууныг дарахаар орсон Барагшинд агуулагдах урсодеооксиголин, холийн хүчил [20] нь холестриныг гэдэсний ханаар шимэгдэхийг бууруулснаар цөсний холестрины хэмжээг багасгана. Гүргэмийн гидроксизаффор шар (HSYA), гүргэмийн гликозид, pyrethrin II, liriotesinol A, 6-hydroxynaringenin, кверцетин зэрэг бүрэлдэхүүн хэсгүүд нь цөсний хүчил үүсэхийг дарангуйлах, цөсний хүчил, цөсний давс, билирубиныг элэгнээс гадагшлуулах замаар холестазыг эмчлэх [21], хонлингийн picoside II (PSII) нь харханд цөсний сувгийг боох аргаар үүсгэсэн элэгний холестатик гэмтлийг сайжруулах үйлчилгээтэй [22]. Дэгд, Алтанцэцэг зэрэгт агуулагдах Ксантон, линолын хүчил [23] нь өөх тосны хэмжээг бууруулахад оролцдог. Рүда нь эфирийн тос, лактон [24] агуулдаг бөгөөд лактон нь цусны реологи чанарын сайжруулдаг. Үүний дүнд бичил цусны эргэлт сайжирч зууралдамтгай чанар буурдаг [25] ба энэ үйлдэл цөсний үүсэлт, өтгөрөлтөд адилаар нөлөөлж чулууг зөөлрүүлэхэд нөлөөлдөг гэж үзэж байна. Жонш, Явууны үнс зэрэгт агуулагдах кальцийн оксид, корбанат, магни зэрэг нь цөсрүү холестрин шимэгдэлтийг багасгах, эсийн дотор гаднах ионы зөрүүгээр цөсний хүүдий болон хуниасны булчингийн агшилт, сулралтад нөлөөлснөөр холестрины чулууг бутлах, үүсэлтийг зогсоох гэх мэт үйлдэлтэй байж болох бөгөөд үүнийг цааш лабораторийн түвшинд судлах шаардлагатай юм.

Дүгнэлт

Ходоодны галын илч бууран тунгалаг цөвөө сайтар ялгаж үл чадсанаар элгэнд муу цус дэлгэрч, түүний цөв болох цөсөнд халуун үүсч, цөв холилдон улмаар шим тогтож тундас үүссэнийг хийгээр хуйлруулж цөсний шарын бэтэг буюу чулуу үүснэ.

Нэмэрт явууны үнс-10 эм дэх бэтгийг эвдэх чадалтай явууны үнс, догшин номхотгосон жонш болон гарнаг 3 нь жорд үндсэн эмээр орж, цөсний шарын бэтэг буюу чулууг задлах үйлдлийг голлон үзүүлж байгаа бол руда нь хавсрах хэлбэрээр үндсэн эмүүдийн чадлыг дэмжих зорилгоор орсон байна. Барагшин, хонлэн, гүргэм 3 нь элгэнд тунгалаг эс шингэж, үүссэн муу цусыг анагаах, дэгд, алтан цэцэг нь цөсөнд үүссэн шарын халууныг дарах, анар нь ходоодны галын илчийг үүсгэн эс шингэснийг шингээх, мөн цөсөнд буусан бадганыг арилгах, арүр нь 3 гэгийг тэгшитгэх үйлдлийг үзүүлж, эдгээр хавсарсан эмүүд нь цөсний шарын бэтгийн өвчин хувирах ёс буюу эмгэг жамын эмчилгээ болж байна.

Ном зүй

1. Болд Ш., Жавхлан Б. Хүннүгээс XXI зууны Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш, бариач нарын цадиг, бүтээлийн ойллого. УБ, 2016
2. http://apps.who.int/iris/bitstream/handle/10665/92455/9789245506096_chi.pdf;jsessionid=94A027BD5008236F24323D55BE006B20?sequence=3 Хандалт хийсэн 2022.07.27
3. Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаал №386. 2010.10.29. http://www.moh.mn/downloads/erkhzui/Undesnii_hotolbor/MOH_2010_386_mong_oliin_ulamjlalt_anagaah_uhaaniig_hogjuuleh_hotolbor.pdf. Хандалт хийсэн 2019.09.10
4. Shih-ChangChuang, EdwardHsi, King-Tehlee. Chapter Five - Genetics of Gallstone Disease. *Advances in Clinical Chemistry*, 2013, Vol.60, p.143-185
5. Эрүүл мэндийн үзүүлэлт 2021. Эрүүл мэндийн хөгжлийн төв. бүлэг 7, хуудас 115,117. http://hdc.gov.mn/media/uploads/2022-05/ERUUL_MENDIIN_UZUULELT_2021.pdf Хандалт хийсэн 2022.07.03
6. 李玉宝. 藏药治疗胆结石十例. *中国秘民族医药杂志*. 1996, 第3期, 26页
7. Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндсээс гутгаар бүлэг увдисын үндэс хэмээх оршвой. Хэвлэлд бэлтгэсэн Ш.Болд, Б.Нямаа. Соёмбо принтинг. УБ, 2012, х.78-90
8. Дэсрид Санжайжамц. Лхантав. Төмөр хөрвүүлсэн. ӨМШУТМХХ. Улаан хад хот, х.73-77
9. Жамбалчойжиданзанпэрэнлай. Увдисын далай. Ганзориг, Буянт хянасан.
10. ӨМШУТМХХ. Улаан хад хот, 2014, х.97-104
10. Өлзийт. Цөсний чулуун бэтгийг эмчилсэн ахмад эмч Дугаржавийн туршлага. *Монгол эм эмнэлэг*. 1992. 3, х. 22-24
11. Санзул, Хай шиа. Цөсний чулуун бэтгийг эмчилсэн ойлголт. *Монгол эм эмнэлэг*. 1994. 2, х. 31-32
12. Нарс Б. Ү жин чангийн эмчилгээний үйлбэр. ӨМШУТМХХ. Улаан хад хот, 2014, х.263-267
13. འཇིགས་མེད་བསྟན་འཛིན་ལྷ་མཚོ། མཐོང་བ་དགའ་བྱེད། 086 ལྷ་མོ་ཚེ་རིང་རྣམས་ཀྱིས་དག་སྤྲོད། མི་རིགས་དཔེ་སྟུན་ཁང་། བེ་ཅིན། འོག 93
14. 孙世民. 血脂与胆结石的相关性分析. *中华医药杂志*. 2004, 9:223.
15. Andrzej Matyja, Krzysztof Gil, Artur Pasternak, Krystyna Sztefko, Mariusz Gajda, Krzysztof A. Tomaszewski, Maciej Matyja, Jerzy A. Walocha, Jan Kulig, Piotr Thor. *Telocytes: new insight into the pathogenesis of gallstone disease. Journal of cellular and molecular medicine*. 2013, Vol17, Issue6, p.734-742
16. Portincasa P., Moschetta A., Palasciano G. Cholesterol gallstone disease. *Lancet*. 2006, 368:230-239
17. Friedman GD., Kannel WB., Dawder TR. The epidemiology of gallbladder disease: observations in the Framingham Study. *J Chronic Dis*. 1996, 19:273-292
18. Leitzmann MF., Rimm EB., Willett WC., Spiegelman D., Grodstein F., Stampfer MJ., et al. Recreational physical activity and the risk of cholecystectomy in women. *N Engl J Med*. 1999, 341:777-784
19. Монгол анагаах ухааны эм найрлага судлал. ӨМАХХ. Хөх хот, 1991, х.17
20. <https://cmjournal.biomedcentral.com/articles/10.1186/s13020-019-0253-x>
21. 乌吉木 吉日木巴图 王蕊. 基于分子对接技术的红花抗胆汁淤积作用机制的研究. *时珍国医国药*. 2019年 第4期, 842-844页
22. <https://www.cnki.com.cn/Article/CJFDTotal-YWPJ201810007.htm>
23. Уламжлалт эмт бодис, жорын хяналтын лавламж. УБ.УАШУТҮК. 2015. Х.137
24. Монголыг уламжлалт анагаах ухааны эм судлал. БШУЯ. 2014. х.140
25. <https://epharma.mn/product/40661?page=1>

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаахын шинжлэх ухааны доктор,
профессор Ч.Чимэдрагчаа*